



**ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН
ТУШААЛ**

2024 оны 03 сарын 28 өдөр

Дугаар А/15

Улаанбаатар хот

Зардал батлах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.2, 16.5.5 дахь заалтуудыг үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол орны эктопаразит болон эктопаразитаар дамжих халдварын үүсгэгчийн тархалтыг тогтоох судалгааны ажлын хүрээнд Завхан, Төв, Өмнөговь, Дорноговь, Баянхонгор, Өвөрхангай аймгийн нутаг дэвсгэрт сонгогдсон цэгт газруудаас хачиг цуглуулж, хачгаар дамжих халдваруудын үүсгэгчийн тархалтыг тогтоох тандалт судалгааг батлагдсан удирдамжийн дагуу чанартай зохион байгуулж ажиллахыг Эрдэм шинжилгээ, сургалт, мэдээллийн технологийн албаны дарга (Д.Алтантогтох)-д үүрэг болгосугай.

2. Тандалт судалгааны ажлын зардал болох 28,701,440 (хорин найман сая долоон зуун нэг мянга дөрвөн зуун дөчин) төгрөгийг холбогдох зардлаас тооцож гаргахыг Ерөнхий нягтлан бодогч (С.Мөнхчимэг)-д зөвшөөрсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны алба (Э.Номин)-нд даалгасугай.

**ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ХАВСРАН ГҮЙЦЭТГЭГЧ**



Б.АМГАЛАНБАЯР

1813100091